



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2015 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

┌ Ажлын байрны сул орон тоог нөхөх тухай ┐

Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн “гурав”-ын 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын сул орон тооны судалгааг 2015 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор гаргаж, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахыг Тамгын газар (Р.Наранцэцэг)-т даалгасугай.

2. Сул орон тоонд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар болон тусгай шаардлагыг хангасан ажилтныг сонгон шалгаруулах ажлын үр дүнг 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Газрын даргын зөвлөлд танилцуулахыг Тамгын газар (Р.Наранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.УРТНАСАН